Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2018 он 11 дүгээр сарын 23 өдрийн
109 дүгээр тогтоолын хавсралт

“АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР”

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг батлагдсан нь аймгийн “Агаар, орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр” боловсруулах нэг үндэслэл болж байгаа юм.

Ховд хотын хүн ам өсөж, төвлөрөл нэмэгдэж байгаагийн улмаас хүрээлэн байгаа орчны бохирдол ихэсч байгаатай холбоотой агаарын бохирдлын эх үүсвэрийг багасгах, экологийн доройтлоос урьдчилан сэргийлэх нь нэн чухал асуудлуудын нэг болж байна. Түүний дотроос агаар, орчны бохирдол нь байгаль орчинд хор хөнөөл учруулаад зогсохгүй нийгэм-эдийн засаг, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх боллоо.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ховд хот нь Буянт голын сав газарт, өндөр уулсаар хүрээлэгдсэн нам дор, хотгор газарт байрладаг учир агаарын солилцоо муу, ялангуяа өвлийн улиралд салхи бага, агаарын даралт өндөр байдгаас шалтгаалж утаа олон цагаар тунаран тогтож, агаарын бохирдол ихтэй аймгуудын нэг болсон. Ялангуяа хүн амын төвлөрөл ихсэж, үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд нэмэгдсэнээс хөрс, ус, агаарын бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс хэд дахин давж байна.

Агаарын бохирдол нь амьсгалын замаар хүний бие, эрүүл мэндэд шууд нөлөөлөхийн хамт агаарт хаягдсан химийн хорт бодис нь богино хугацаанд их хэмжээний газарт тархдаг.

Ховд аймгийн нийт хүн амын 34,5 хувь нь Жаргалант суманд амьдардаг. Ховд хотын агаарын бохирдол сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна.

Ховд хотод байгаа агаар, орчныг бохирдуулж байгаа эх үүсвэрүүд:

- Дулааны станц	2
- Нам даралтын зуух	49
- Тээврийн хэрэгсэл	15721
- Ердийн галлагаатай зуух бүхий аж ахуйн нэгж, иргэн	222

- Гэр хорооллын айл өрхүүдийн зуух 5130

- Шатахуун түгээх ста 17

- Төвлөрсөн 6

- Эвдрэл, элэгдэлд орсон газраас боссон тоос шороо зэрэг хүчин зүйлүүд багтана.

Одоогийн байдлаар төвлөрсөн уурын зуухнаас жилд 145400 тонн нүүрс түлснээр хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн давхар исэл, тоосонцор, дэгдэмхий бодис, тортгоос бүрдсэн 434 мг/м^3 хорт бодис агаарт хаягдаж, хорт бодисын хэмжээ ихсэж байна. Сүүлийн жилүүдэд цөлжилт ихээр явагдаж, элсний нүүдэл хурдацтай тархаж байгаагаас үүдэн хот орчмын хөрснөөс боссон тоос, шороон шуурга нь жилийн 4 улиралд агаарын бохирдолд багагүй нөлөө үзүүлж байна.

Ховд аймгийн Жаргалант сум 29800 хүн амьтай. 8200 айл өрхтэй. Жаргалант сумын гэр хорооллын 5130 гаруй айл өрх жилд 13385.61 тонн түүхий нүүрс хэрэглэж байна.

Хөрсний бохирдол

Жаргалант сум 2017 оны статистик мэдээллээр 12 багийн 188 гудамжтай, энгийн бие засах 4249 нүхэн жорлонтой, бохир усны 3746 цооногтой, энгийн гар худаг 361, инженерийн хийцтэй худаг 97, албан байгууллагууд аж ахуйн нэгжүүд 78 нүхэн жорлонтой гэсэн тоо баримт байна. Айл өрхүүдийн 25.0-30.0 хувь нь эрүүл мэндийн шаардлага хангаагүй нүхэн жорлонг хэрэглэж байна. Ялангуяа Рашаант, Наран, Цамбагарав багуудын айл өрхүүд шаардлага хангаагүй нүхэн жорлонг ашиглаж байна. Зөвхөн Наран, Рашаант, Цамбагарав багийн нутаг дэвсгэрт 206 энгийн худаг байгаа бөгөөд стандартын хувьд худгаас жорлон 25 м байх ёстойгоос 5-8 м-т нэг жорлон байх жишээтэй. Иймд энэ багуудад гэдэсний өвчин их байгааг статистикаас харж болно.

Уурын зуухнуудын техник технологи муудаж хуучирснаас дутуу шаталт явагддаг, утаа шүүх төхөөрөмжийг бүрэн ашигладаггүй, аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүд нам даралтын зуухаар дулаан хангамжийн асуудлаа шийдвэрлэж байгаа шалтгаанаас агаарт ялгарах бохирдлын хэмжээ ихсэж байна.

2017 оны байдлаар авто тээврийн улсын үзлэгээр тоологдсон бүх төрлийн хөдөлгөөнт эх үүсвэр буюу тээврийн хэрэгсэл 15721 бүртгэгдсэнээс суудлын автомашин 10679 буюу 66,1 хувь, ачааны машин 4564 буюу 27,2 хувь, нийтийн тээвэр 141 буюу 0,9 хувь, тусгай зориулалтын машин 337 буюу 2,1 хувийг тус тус эзэлж байна. 2016 онтой харьцуулан үзэхэд 1505 автомашин нэмэгдсэн байна. Нийт тээврийн хэрэгслийн 82.0 хувь нь 10-аас дээш жил эдлэгдсэн хуучин автомашин тээврийн хэрэгсэл байна.

Авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгаран гарч буй утаа нь хүний амьсгалах түвшинд ойр зайд буюу 0.2 м өндөрт цацагддаг бөгөөд түүний найрлагад хүний амьсгалын замын цочмог болон архаг өвчин, харшлын эмгэг үүсгэх, элэг, бөөр, уушгийг гэмтээх, зүрх судас, мэдрэл сэтгэхүйн системийн эрхтний үйл ажиллагааг алдагдуулах, амьсгал боох, хорт хавдар үүсгэх үйлчилгээтэй нүүрстөрөгчийн исэл, азотын исэл, нүүрс устөрөгч, хүхэрлэг хий, хөө тортог, хар тугалга, бенз-/а/-пирен, альдегид зэрэг хорт бодис агуулж байдаг байна.

Хийн мандлын агаарыг бохирдуулагч нь хүний бие махбодын дархлалын урвалыг өөрчилж, гадны эмгэг төрүүлэгч нянгуудыг эсэргүүцэх чадварыг сулруулж улмаар хүүхдийн амьсгалын замын өвчлөл 2016 онтой харьцуулахад 3 дахин, насанд хүрэгчдийнх 1.8 дахин нэмэгдсэн төдийгүй харшил үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Манай аймагт газарзүйн байрлалын хувьд хотгор газар байршилтай тул ялангуяа төвийн орчимд өвлийн улиралд салхины хурд бага, хотын дээр агаарын температурын тонгоруу тогтож агаарт утаа тортог, элдэв хорт хийн хольцууд нэмэгдэх нэгэн нөхцөл болдог.

Ховд аймгийн агаарын чанарын хяналт шинжилгээний харуул нь 1985 оны 09 дүгээр сарын 02-нд байгуулагдсан. 2004 оны 05 дугаар сарын 19-нд Байгаль орчны шинжилгээний лаборатори болгон өргөжсөнөөр ус, агаар, хөрсний шинжилгээг хийж байна.

Агаарын бохирдлыг 4 үндсэн үзүүлэлтээр өдөр бүр 08, 14, 20 цагт цаг уурын 5 үзүүлэлтээр тус тус хэмжиж байна.

Агаар дахь хүхэрлэг хийн олон жилийн мэдээ материалаас харахад хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж 2009 оноос хойш өсөх хандлагатай байгаа ба хамгийн их утга 2014 онд ажиглагдаж 0,011 мг/м^3 буюу агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээ / АЧС дахь ХХХ/-ээс 0,001 мг/м^3-аар буюу 10 хувиар давсан байна.



Агаар дахь азотын давхар ислийн дундаж агууламж 2006-2014 оны хооронд өсөх хандлага ажиглагдсан. 2007 онд Агаар дахь азотын давхар ислийн дундаж агууламж хамгийн их утгатай ажиглагдаж графикт тэмдэглэгдсэн байна.

2015-2017 онуудад азотын давхар ислийн дундаж агууламж агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давах хандлагатай байна.



Агаар дахь тоосонцрын жилийн дунджаас харахад 2012 онд хамгийн их буюу агаар дахь тоосонцрын хүлцэх хэм хэмжээнээс 6,5 дахин давсан бөгөөд бусад жилүүдэд 2.4-5.8 дахин давсан үзүүлэлт ажиглагдсан байна.



ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1.Ховд хотын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн бохирдлын эх үүсвэрийг багасгаж, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд аймгийн дэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

Зорилт-1. Аймгийн дэд бүтцийг хөгжүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлж, суурин газрын агаар, орчныг сайжруулах.

Зорилт-2. Агаар, орчныг бууруулахад хүлэмжийн хийг багасгаж нийтийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

Зорилт-3. Байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах. /Гэр хорооллын айл өрх, дулааны станц руу чиглэсэн/

Зорилт-4. Авто тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах. /10-аас дээш жилийн насжилттай 82.0 хувьтай байгаа жил бүр 1505 автомашин дунджаар нэмэгддэг/

Зорилт-5. Орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОРИЛТУУД

3.1. Аймгийн дэд бүтцийг хөгжүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлж, суурин газрын агаар, орчныг сайжруулах.

3.1.1. Ховд цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ, дэд станцыг өргөтгөн хүчин чадлыг нь нэмэгдүүлж, гэр хорооллын айл өрх 2.5-4 квт хүчин чадалтай цахилгаан халаагуур ашиглах техникийн боломжийг бүрдүүлэх.

3.1.2. Гэр хорооллын айл, өрхүүдэд хоёр тарифт тоолуурыг үе шаттайгаар суурилуулах ажлыг хэрэгжүүлж, шөнийн цахилгааны тарифын хөнгөлөлтөд хамруулах.

3.1.3. Нар, салхи, газрын гүний дулаан зэрэг сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.

3.1.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг дэмжиж урамшуулах.

3.1.5. Монголын ипотекийн корпорацын “Түрээсний орон сууц хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

3.1.6. Гэр хорооллын иргэдийг хямд өртөг бүхий орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх.

3.1.7. “Хашаандаа сайхан амьдаръя” загвар төслийг үе шаттай эхлүүлэх

3.1.8. Нам даралтын зуух ашиглаж буй барилгуудыг төвлөрсөн халаалтын шугамд холбох замаар нам даралтын уурын зуухыг үе шаттайгаар цөөрүүлнэ.

3.2. Агаар, орчныг бууруулахад хүлэмжийн хийг багасгаж нийтийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх.

3.2.1 Орон сууц, гэр хорооллын нийтийн эзэмшлийн талбайд зураг төслийн дагуу бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах

3.2.2. Гудамж талбайн ургамлын бүрхэвчгүй сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлэх

3.2.3. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мод тарих санал санаачилгыг дэмжих

3.2.4. Агаарын бохирдол ихтэй багуудын эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах

3.2.5. Агаар, орчны бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга барилыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа, хамгааллын арга хэмжээг зохион байгуулах

3.2.6. Агаар, орчны бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх

3.2.7 Агаар, орчны бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээлэл, нотолгоо бүрдүүлэх судалгаа хийх.

3.3. Байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах. /Гэр хорооллын айл өрх, цахилгаан станц руу чиглэсэн/

3.3.1. Агаарын тухай хуулийн дагуу Агаарын чанарыг сайжруулах бүсийг тухай бүр шинэчлэн тогтоож, журмын хэрэгжилтийг хангах

3.3.2. Түлш, гэрийн зуухны холбогдох стандартыг айл өрхөд мөрдүүлэх

3.3.3. Шахмал түлш нөөцлөх, түгээлт, борлуулалтын цэгүүдийг бий болгох

3.3.4. Жаргалант сумын гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчийг баг тус бүрээр хөнгөлөх

3.3.5. Агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот бүлгийн айл өрхүүдэд сайжруулсан зуух, шахмал түлш болон цахилгаан халаагуур, янданд индукцийн шүүлтүүрүүдийг суурилуулах ажлыг зохион байгуулах.

3.3.6. Монгол гэрийн дулааны алдагдлыг бууруулах чиглэлээр стандартыг шинэчилж мөрдүүлэх

3.4. Авто тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах. /10-аас дээш жилийн насжилттай 82.0 хувьтай байгаа жил бүр 1500 автомашин дунджаар нэмэгддэг/

3.4.1. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг чанаржуулах

3.4.2. Замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгсэлд утааны хэмжилтийг хийх.

3.4.3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулиудын хэрэгжилтийг ханган ажиллаж, төвлөрсөн орлогыг агаарын бохирдлыг бууруулахад зарцуулна.

3.5. Орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх.

3.5.1. Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэд техник технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар болон агаар, орчны бохирдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд сургахад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах

3.5.2. “Ховд хотын агаарын бохирдлыг бууруулахад иргэн таны оролцоо” аян өрнүүлэх

3.5.3. Байгаль орчин, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчилж, зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээг зохион байгуулах

3.5.4. Гэр хорооллын нутаг дэвсгэрт “Агаарын бохирдлын хяналт” мониторинг явуулж, автомашины дугуй, автомашины ажилласан тос зэрэг хог хаягдал шатааж байгааг хянах, зорилтот бүлгийн өрхийн судалгааг нягталж гаргах ажлыг иргэний нийгмийн байгууллагатай хамтарч хэрэгжүүлэх

3.5.5. Аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн лабораторийг PM10, PM2.5 тоосонцор хэмжих автомат багажаар тоноглох

3.5.6. Агаарын орчны бохирдол ихтэй бүсүүдэд судалгаа явуулж, бохирдуулах бодисын агууламж, бохирдлын нөлөөллийг нарийвчлан тогтоох

3.5.8. Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл тооллого явуулж, бүртгэл мэдээллийн цахим санг бүрдүүлэх

3.5.9. Дулааны станцаас гарч буй үнсийг хуримтлал үүсгэхгүйгээр устгах, бохирдлыг бууруулах, үнсийг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжих

ДӨРӨВ. АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

4.1. Дэд хөтөлбөрийг 2019-2022 онд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.1.1. нэгдүгээр үе шат: 2019-2020 он;

4.1.2. хоёрдугаар үе шат: 2020-2022 он.

ТАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

5.1. Дэд хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, ажлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. агаар бохирдуулсны төлбөрийн орлого;

5.1.3. Төсөл, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;

5.1.4. бусад эх үүсвэр.

5.2. АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго		Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн бохирдлын эх үүсвэрийг багасгаж, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар, орчныг бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ									
Үр нөлөө /үр нөлөөний шалгуур үзүүлэлт/		Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр байгальд ээлтэй инженерийн дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг сайжруулж, агаар, орчныг бохирдуулагч эх үүсвэрийг багасган түүхий нүүрсийг хязгаарлаж, аймгийн агаар, орчны бохирдлыг 40.0 хувиар бууруулна									
Үйл ажиллагаа		Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Төсөв /сая,төг/						Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа он	
				2019	2020	2021	2022	Орон нутгийн төсөв	Улсын төсөв			
Зорилт-1. Аймгийн дэд бүтцийг хөгжүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлж, суурин газрын агаар, орчныг сайжруулах.												
3.1.1.	Ховд цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ, дэд станцыг өргөтгөн хүчин чадлыг нь нэмэгдүүлж,гэр хорооллын айл өрх 2.5-4 квт хүчин чадалтай цахилгаан халаагуур техникийн боломжийг бүрдүүлэх	Цахилгаан дамжуулах сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр дэд станц байгуулах	2500 айл өрхийг 2,5-4 квт цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлсэн байна.	146,0	15,0	15,0	15.0			Цахилгаан түгээх сүлжээ ХХК	2019-2022	
3.1.2	Гэр хорооллын айл, өрхүүдэд хоёр тарифт тоолуурыг үе шаттайгаар суурилуулах ажлыг хэрэгжүүлж, шөнийн цахилгааны тарифын хөнгөлөлтөд хамруулах.	450 айлд хоёр тарифт тоолуур суурилуулсан байна.	4500 айлд шинээр хоёр тарифт тоолуур суурилуулсан байх.	87,0	87,0	87,0	87,0			Ховд Цахилгаан түгээх сүлжээ ХХК	2019-2022	
3.1.3	Нар, салхи, газрын гүний дулаан зэрэг сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	10 мвт-ийн сэргээгдэх эрчим хүчний төслүүд	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, ашиглалт нэмэгдсэн байна.	-	-	-	-			Аймгийн ЗДТГ, Ховд цахилгаан түгээх ХХК, ЭХЗХороо	2019-2020	

3.1.4	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг дэмжиж урамшуулах.	Урамшуулах систем байхгүй.	Иргэн аж ахуйн нэгжүүдийг урамшуулах журам боловсруулж хэрэгжүүлэх.	-	10,0	10,0	10,0			БОАЖГ, Ховд цахилгаан түгээх ХХК, ЭХЗХороо	2020-2022
3.1.5	МИК "Түрээсийн орон сууц хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	120 айлын түрээсийн орон сууцны барьсан.	120 айл түрээсийн орон сууцаар хангагдах болж бүрдэнэ	-	-	-	-	-	-	ГХБХБГазар Монголын Ипотекийн корпораци	2019-2022
3.1.6	Гэр хорооллын иргэдийг хямд өртөг бүхий орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Зураг, төсөл боловсруулж төсөл хэрэгжиж эхэлсэн байна.	50,0	60,0	-	-			ГХБХБГазар	2019-2020
3.1.7	"Хашаандаа сайхан амьдарцгаая" загвар төслийг үе шаттай эхлүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Загвар төслийг хэрэгжүүлсэн байна.	100,0	150,0	100,0	50,0	-	-	Аймгийн ЗДТГ ТББайгууллагууд	2019-2022
3.1.8	Нам даралтын зуух ашиглаж буй барилгуудыг төвлөрсөн халаалтын шугамд холбох замаар нам даралтын уурын зуухыг үе шаттайгаар цөөрүүлнэ.	49 нам даралтын уурын зуухнуудыг үе шаттайгаар цөөрүүлэх .	2,5 км шугам шинээр барьж нам даралтын уурын зуухнуудыг үе шаттайгаар зогсоосон байна.	800,0	800,0	800,0	800,0	-	-	Дулааны станц	2019-2022
Зорилт-2. Агаар, орчныг бууруулахад хүлэмжийн хийг багасгаж нийтийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх.											
3.2.1	Орон сууц, гэр хорооллын нийтийн эзэмшлийн талбайд зураг төслийн дагуу бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах	Шинээр байгуулсан бичил цэцэрлэгт хүрээлэн	2-3 бичил цэцэрлэгт хүрээлэнг байгуулсан байна. Тарьсан мод сөөгийн амьдралт 70-80 хувьтай болсон байна.	150,0	150,0	100,0	50,0	-	-	Жаргалант сумын ЗДТГ, Хот тохижилтын газар, Сум дундын Ойн анги	2019-2022
3.2.2	Гудамж талбайн ургамлын бүрхэвчгүй сул шороон хөрс бүхий талбайг	500 мянган кв,м талбайг зүлэгжүүлсэн байна	Жилд 1000 мянган кв,м талбайг зүлэгжүүлсэн байна.	25,0	30,0	25,0	30,0			Жаргалант сумын ЗДТГ, Хот тохижилтын газар, Сум дундын	2019-2022

	зүлэгжүүлэх									Ойн анги	
3.2.3	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мод тарих санал санаачилгыг дэмжих	Гэр бүл, албан байгууллага, төгсөлт, хамт олны нэрэмжит төгөл	Ногоон бүсэд мод тарих нэрэмжит цэцэрлэгүүдийг бий болгож, гэр бүл, төгсөлт, хамт олны нэрэмжит төгөл тарих нөхцөлийг бүрдүүлсэн байна.	5,0	5,0	2,0	2,0			Жаргалант сумын ЗДТГ, Хот тохижилтын газар, Сум дундын Ойн анги	2019-2022
3.2.4	Агаарын бохирдол ихтэй багуудын эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах	Эрүүл мэндийн газрын даргын тушаал	Томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулсан хүн ий тоо.	15,0	10,0	5,0	10,0			Эрүүл мэндийн байгууллагууд	2019-2021
3.2.5	Агаар, орчны бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгаа хийх	Сургалт сурталчилгаа, амны хаалтын хэрэглээ, агаар цэвэршүүлэгч суурилуулсан, агааржуулалтыг сайжруулсан сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон бусад албан газрууд	Хүн амд зориулсан ухуулга сурталчилгаа, гарын авлага боловсруулж, нийтийн хүртээл болгосон байна.	5,0	10,0	15,0	10,0			Эрүүл мэндийн байгууллагууд	2019-2022
3.2.6	Агаар, орчны бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх	Холбогдох журам, стандарт мөрдөх	Иргэдэд зориулсан ухуулга сурталчилгаа, гарын авлага боловсруулж, нийтийн хүртээл болгосон байна	5,0	10,0	15,0	10,0			Эрүүл мэндийн байгууллагууд	2019-2022
3.2.7	Агаар, орчны бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээлэл, нотолгоо бүрдүүлэх судалгаа	Холбогдох журам, стандарт мөрдөх	Иргэдийн өвчин үүсэхэд үзүүлэх нөлөөллийн судалгаа хийж, үр тогтоосон байна	5,0	2,0	3,0	3,0			Эрүүл мэндийн байгууллагууд	2019-2022

	хийх.										
Зорилт-3. Байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах. /Гэр хорооллын айл өрх, цахилгаан станц руу чиглэсэн/											
3.3.1.	Агаарын тухай хуулийн дагуу Агаарын чанарыг сайжруулах бүсийг тухай бүр шинэчлэн тогтоож, журмын хэрэгжилтийг хангах	Бүсийг шинэчлэн тогтоосон шийдвэр, бүсэд мөрдөх журам	БОАЖСайд, аймгийн Засаг даргын хамтран тогтоосон, агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, журмын хэрэгжилтийг хангуулсан байна.	10,0	5,0	12,0	8,0			Аймгийн ЗДТГ БОАЖГазар, аймгийн МХГ, УЦУОШТөв,	2019-2022 он
3.3.2.	Түлш, гэрийн зуухны холбогдох стандартыг айл өрхүүд мөрдүүлэх	Түлш, зуухны стандартууд	Холбогдох стандартуудыг боловсруулж, мөрдүүлсэн байна.	50,0	60,0	70,0	50,0			Аймгийн ЗДТГ БОАЖГазар, аймгийн МХГ, УЦУОШТөв,	2019-2022
3.3.3.	Шахмал түлш нөөцлөх, түгээлт, борлуулалтын цэгүүдийг бий болгох	Шахмал түлшний нөөцлөх цэг, борлуулалтын сүлжээ	Түгээлт борлуулалтын цэгүүдийг байгуулсан байна.	150,0	200,0	150,0	-	-	-	Аймгийн ЗДТГ Жаргалант сумын ЗДТГ	2019-2022
3.3.4	Жаргалант сумын гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчийг баг тус бүрээр хөнгөлөх	Шөнийн цахилгаан эрчим хүчийг хөнгөлөлт	Түүхий нүүрсний шаталтаас үүдэлтэй агаарын бохирдол буурсан байна.	50,0	60,0	40,0	40,0			Аймгийн ЗДТГ Ховд Цахилгаан түгээх сүлжээ ХХК Жаргалант сумын ЗДТГ	2019-2022
3.3.5.	Агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот бүлгийн айл өрхүүдэд сайжруулсан зуух, шахмал түлш болон цахилгаан халаагуур, янданд индукцийн шүүлтүүрүүдийг суурилуулах ажлыг зохион байгуулах.	Дэмжлэгт хамруулж, зуух, шахмал түлш, гэрийн дулаалга олгосон зорилтот бүлгийн айл өрх	500-600 зорилтот бүлгийн өрхийг дэмжлэгт хамруулсан байна.	25,0	30,0	60,0	70,0			Аймгийн ЗДТГ Байгаль орчин, аялал жуулчлалын газар	2019-2022
3.3.6.	Монгол гэрийн дулааны алдагдлыг бууруулах чиглэлээр стандартыг шинэчилж мөрдүүлэх	Монгол гэрийн стандарт	Гэрийн стандартыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлсэн байна.	30,0	15,0	30,0	40,0			Аймгийн ЗДТГ Жаргалант сумын ЗДТГазар Эрүүл орчин зөв амьдрал ТББ	2019-2022

Зорилт 4: Авто тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах. /10-аас дээш жилийн насжилттай 82 хувьтай байгаа жил бүр 1500 автомашин дунджаар нэмэгддэг/											
3.4.1.	Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг чанаржуулах	Стандартын шаардлага хангасан автомашин, сургалт, дадлагад хамрагдсан инженер техникийн ажилтнуудад	Авто машин тээврийн хэрэгслээс үүдэлтэй бохирдол буурна. Техникийн хяналтын үзлэгийн инженер техникийн ажилтнуудыг сургалтад хамрагдаж, ур чадвар дээшилсэн байна.	5,0	5,0	-	-	-	-	Аймгийн Авто тээврийн төв, Замын цагдаагийн тасаг	2019-2020
3.4.2	Замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгсэлд утааны хэмжилтийг хийх.	Тээврийн хэрэгслийн шугам замын хэмжилт, хяналт	Замын цагдаагийн албан хаагчид 10 ш утаа хэмжигч багажаар хяналт шалгалтыг ажлыг хэрэгжүүлнэ.	10,0	8,0	10,0	10,0			Аймгийн Авто тээврийн төв Замын цагдаагийн тасаг	2019-2022
3.4.3	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулиудын хэрэгжилтийг ханган ажиллаж, төвлөрсөн орлогыг агаарын бохирдлыг бууруулахад зарцуулна.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Агаарын тухай, Газрын төлбөрийн тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай, Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай, ЗГ-ын тусгай сангийн тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай, Зөрчлийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх	Эдгээр хуулиудыг хэрэгжүүлэн ажиллах	35,0	40,0	50,0	65,0			Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэс БОАЖГазар Татварын хэлтэс	2019-2022
Зорилт 5: Орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх.											
3.5.1	Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэд техник технологи, ногоон	Орон нутгийн ТВ нэвтрүүлэг, богино хэмжээний видео шторк, сургалт, сурталчилгаа	Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршгийн, дэвшилтэд техник технологи, ногоон	10,0	15,0	15,0	15,0			Аймгийн ЗДТГазар БОАЖГ Жаргалант сумын ЗДТГ	2019-2022

	амьдралын хэв маягийн талаар болон агаар, орчны бохирдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд сургахад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах		амьдралын хэв маяг, зөв дадал, хэвшлийн талаар олон нийтэд ойлголт мэдлэг өгөгдсөн байна.								
3.5.2	“Ховд хотын агаарын бохирдлыг бууруулахад иргэн таны оролцоо” аян өрнүүлэх	Мэдээл сургалт сурталчилгааны ажлын төлөвлөгөө гаргах	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар олон нийтэд сурталчилсан байна.	10,0	10,0	10,0	10,0			БОАЖГ Жаргалант сумын ЗДТГ Эрүүл мэндийн төв	2019-2022
3.5.3.	Байгаль орчин, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчилж, зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээг зохион байгуулах	Сурталчилгаа, хяналт шалгалт	Хууль тогтоомжийн зөрчлийг таслан зогсоосон байна.	2,0	2,0	2,0	2,0			Аймгийн МХГазар БОАЖГ Эрүүл мэндийн төв	2019-2022
3.5.4.	Гэр хороллын нутаг дэвсгэрт “Агаарын бохирдлын хяналт” мониторинг явуулах, энэ хүрээнд дугуй, Автомашины ажилласан тос зэрэг хог хаягдал шатааж байгааг хянах, зорилтот бүлгийн өрхийн судалгааг нягталж гаргах ажлыг иргэний нийгмийн байгууллагатай хамтарч хэрэгжүүлэх	Гэр хороололд идэвхтэн байгаль хамгаалагчдыг улирлын чанартай ажиллуулж, судалгаа гаргуулж, байнга хяналт тавих	Иргэний нийгмийн байгууллагатай хамтран идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж, хяналт эргүүл хийж, агаарын чанарыг сайжруулах бүсийн дэглэмийг мөрдүүлж, холбогдох судалгааг гаргаж олон нийтэд хууль тогтоомжийн мэдээлэл хүргэсэн байна.	2,0	3,0	4,0	3,0			Аймгийн МХГазар Жаргалант сумын ЗДТГ, БОАЖГазар	2019-2022
3.5.5.	Аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн лабораторийг	PM10, PM2.5 тоосонцор хэмжих автомат	PM10, PM2.5 тоосонцрын агууламжийг 1 цаг	54,0	60,0	-	-	-	-	Аймгийн ЗДТГ УЦУОШТөв	2019-2020

	PM10, PM2.5 тоосонцор хэмжих автомат багажаар тоноглох		тутамд тодорхойлох автомат багажаар 1-2-аас доошгүй газар тоноглогдсон байна.								
3.5.6.	Агаарын орчны бохирдол ихтэй бүсүүдэд судалгаа явуулж, бохирдуулах бодисын агууламж, бохирдлын нөлөөллийг нарийвчлан тогтоох	Нарийн хэмжлийн 5-аас доошгүй аналитик багаж төхөөрөмж	Агаар, ус, хөрсний сорьцод бенз /а/, пирен, дэгдэмхий органик нэгдэл зэрэг хорт бодис, хүнд металл тодорхойлдог болсон байна.	60,0	80,0	90,0	-	-	-	Аймгийн ЗДТГ УЦУОШТөв	2019-2021
3.5.7	Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл тооллого явуулж, бүртгэл мэдээллийн цахим санг бүрдүүлэх	Агаарын бохирдлын эх үүсвэр ААНБ, өрхийн бүртгэл мэдээллийн цахим сан	Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл, мэдээллийн цахим санг бүрдүүлж, хөтлөн явуулдаг болсон байна.	5.0	5.0	5.0	5.0			Аймгийн ЗДТГ УЦУОШТөв Жаргалант сумын ЗДТГ	2019-2022 он
3.5.8	Дулааны станцаас гарч буй үнсийг хуримтлал үүсгэхгүйгээр устгах, бохирдлыг бууруулах, үнсийг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжих	Үнсээр бохирдсон талбайг зүлэгжүүлэх, үнсийг дахин ашиглалт	Үнсээр бохирдсон талбайн хэмжээг багасгаж, тоосжилт буурсан байна.	20.0	20.0	-	-	-	-	Аймгийн ЗДТГ Бадамлах дөл ХХК, Ховд Дулааны станц ТӨХК	2019-2020 он

ЗУРГАА. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1.1. Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Мэргэжлийн хяналтын газар хариуцна.

6.1.2. Дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн хөгжлийн стратеги хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр амьд байгалийн тулгуур орчин болсон хий мандлын агаарыг цэвэр, ариун байлгаж, иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдүүлж дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

7.1.1. Нүүрсний чанарт тохирсон техник, технологийн шинэчлэл хийж, шахмал түлшийг хэрэглэж, түлшний чанарыг сайжруулах болон утааг шүүх, цэвэрлэх шинэ загварын шүүлтүүр тавьж горимын дагуу байнга хэвийн ажиллуулах, бохирдлын зөвшөөрлийн тогтолцоог нэвтрүүлэх, үндсэн дээр төвлөрсөн уурын зуухнуудын ашиглалтыг сайжруулж, нам даралтын уурын зуухнуудыг зогсоож суурин эх үүсвэрүүдийн агаарт гарах бохирдлыг 2019-2022 онуудад шат дараатай бууруулах.

7.1.2. Экологийн магадлан оношлогоонд тээврийн хэрэгслийг бүрэн хамруулах, сайн чанарын шингэн болон дэвшилтэд шинэ төрлийн түлш хэрэглэх ажлыг өргөжүүлэх замаар хөдөлгөөнт эх үүсвэрийн агаарт гарах бохирдлын хэмжээг 1,5 дахин бууруулах.

7.1.3. Бүрэн шаталт явагдах технологи бүхий эдийн засагт хэмнэлттэй, утаа бага гаргадаг стандартын шаардлага хангасан зуух, шүүлтүүрүүдийг Жаргалант сумын гэр хорооллын 5130 өрхүүдэд тавьж, 2022 оны түвшинд бүрэн, утаагүй түлшээр хангаж, гэр хорооллоос гарах бохирдлыг өнөөгийн түвшингөөс 2 дахин бууруулна.

7.1.4. Ховд хотын агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэрүүдийг шинээр байгуулах асуудлыг бодлогоор зохицуулах, шинээр нам даралтын зуухнуудыг суурилуулахгүй байх, удирдлага, зохион байгуулалтын болон эдийн засгийн хөшүүргийг нэвтрүүлснээр хотын агаарын бохирдлыг 2022 оны түвшинд 40-өөс багагүй хувиар багасгана.

Найм. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтэс хяналт тавьж үр дүнг тооцно.

8.2. Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна.

8.3. Дэд хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж, тайланг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

.....oOo.....